



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮАГ-ын 2018 оны бүтээгдэхүүн ажил
үйлчилгээний төлөвлөгөө, нэгдсэн удирдамжийн
дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”



**Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагууд
шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.**

<p>Тайланг бэлтгэсэн:</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт.....2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....3-4</p>
<p>ААГ-ын НА-ын баг</p> <p>Газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат</p> <p>Аудитын менежер Ш.Мөнхбаяр</p> <p>Аудитор С.Санжаажав</p>	<p>БҮЛЭГ-1: Өмнөх аудитын дүнтэй харьцуулбал зөрчлийн дүн 5,626.7 сая төгрөгөөр буурсан байна.</p> <p>1. Аудитын дүн.....5 1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд бүрэн хамрагджээ.....5 1.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд мэдээллээ тогтмол байршуулж хэвшиж байна.....5-8</p>
<p>2018 оны 11 дүгээр сар Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-8845, 7037-8142 дугаарын утсаар харилцана уу.</p>	<p>БҮЛЭГ-2: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.</p> <p>2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах ААН-үүдийн 66 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаагүй байна.....9 2.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах ААН-үүд 65 төсөл, хөтөлбөрийн 5.760,4 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.....9-11</p>
<p>ХАЯГ: Дархан-Уул аймгийн Дархан сум 14-р баг Аймгийн ЗДТГ-ын байр 305 тоот Аймгийн аудитын газар</p>	<p>БҮЛЭГ-3: Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-д заасан байгууллага, албан тушаалтан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсэн байна.</p> <p>3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-д хамаарах байгууллага хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна..... 12-13 3.2.Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж 66 хувьтай хэрэгжсэн байна..... 13</p> <p>АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:</p> <p>ДҮГНЭЛТ.....14 ЗӨВЛӨМЖ.....14</p>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТӨХ ОНӨХЭ	Төрийн өмчит хуулийн этгээд Орон нутгийн өмчит хуулийн этгээд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААН	Аж ахуйн нэгж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу аудитыг хийлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д заасан байгууллага, албан тушаалтныг бүрэн хамруулж шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж, дүнг аудитын тайланд тусгав.

Аудитаар 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хамруулж гүйцэтгэлээ.

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго:

Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршив.

Арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх холбогдох албан тушаалтнуудтай уулзалт,

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Төрийн өмчит үйлдвэрийн газрууд

³ Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

⁴ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

⁵ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

ярилцлага зохион байгуулах, иргэд хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Үндсэн мэдээлэл:

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийг тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн.

Аймгийн хэмжээнд шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах 127, 3.1.2-д хамаарах 1, 3.1.3-д хамаарах байгууллага 5, 3.1.4-д хамаарах 50, 3.1.5-д хамаарах 28, нийт 211 байгууллага, аж ахуй нэгж байна.

Үүнээс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлгүй хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах 33 аж ахуйн нэгж байна.

БҮЛЭГ 1

**Өмнөх аудитын дүнтэй харьцуулбал зөрчлийн дүн
5,759.6 сая төгрөгөөр буурсан байна.**

НЭГ: АУДИТЫН ДҮН

Дархан-Уул аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах, хамрагдвал зохих нийт 211 байгууллага байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хамаарах хуулийн этгээд	Тоо
1	Хуулийн 3.1.1-д хамаарах /ТӨХЭ, ОНӨХЭ, ОНӨААТҮГ, ОНӨҮГ /	127
2	Хуулийн 3.1.2-д хамаарах / ТӨҮГ, ТӨААТҮГ /	1
3	Хуулийн 3.1.3-д хамаарах / ХК, ТӨХК /	5
4	Хуулийн 3.1.4-д хамаарах /иргэн, ААН/	50
5	Хуулийн 3.1.5-д хамаарах / Хувийн өмчийн сургууль, цэцэрлэг /	28
	Нийт дүн	211

Харин 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар 185 байгууллагын цэс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байгаагаас татан буугдсан 5 байгууллагын цэс бүртгэлтэй хэвээр байна. Тухайлбал:

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах:

1. ТЭДС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д хамаарах

1. Цэлмэг цэцэрлэг
2. Наргил-Атно цэцэрлэг
3. Мөнгөлдэй цэцэрлэг
4. 23 дугаар сургууль

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-д хамаарах байгууллагууд бүрэн хамрагджээ.

1.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах нийт 127 байгууллагын цэс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үүсгэгдэж мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан байна. Эдгээрээс ТЭДС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар татан буугдсан ч бүртгэлтэй хэвээр байв.

Иймд татан буугдсан байгууллагыг тухай бүрд нь бүртгэлээс хасаж байхыг журмаар зохицуулж өгөх шаардлагатай байна.

1.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д хамаарах Дархан-Уул аймаг дахь Авто тээврийн төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй, мэдээлэл байршуулах боломжоор хангагджээ.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд мэдээллээ тогтмол байршуулж хэвшиж байна.

Шилэн дансны тухай хуульд мэдээллийг үнэн зөв, бодитой, тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлэх талаар хуульчилж өгсөн. Үүний дагуу хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын 2017 оны 4-р улирал, 2018 оны 1-3 дугаар улирлаар тасалбар болгон шалгахад дараах байдалтай байна.

1.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах нийт 128 байгууллага аудитад хамрагдсанаас Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁶-д заасан тухайн жилийн батлагдсан төсвийг 127 нь буюу 99.6 хувь, ХАА-ны болон ОНХС-ийн төлөвлөгөөг 100 хувь мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2⁷-т заасан төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 08 дугаар сарыг дуустал 128 байгууллага 100 хувь мэдээлсэн бол 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийг 99.6 хувьтай мэдээлсэн байв.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 100 хувь, хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг 99.6 хувьтай мэдээлсэн байна.

Тухайлбал: “Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийг, Зэвсэгт хүчний 322 дугаар анги хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг тус тус мэдээлээгүй байлаа.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁸-д заасан дараа жилийн төсвийн төслийг мэдээлбэл зохих 128 байгууллагаас 124 нь буюу 96.9 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁹-т заасан хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг мэдээлбэл зохих 128 байгууллагаас хагас жилийн санхүүгийн тайланг 126 нь буюу 98.4 хувь нь, жилийн эцсийн санхүүгийн тайланг 121 нь буюу 94.5 хувь нь мэдээлсэн байв.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5¹⁰-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлбэл зохих 128 байгууллагаас 127 нь буюу 99.2 хувь нь, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 115 нь буюу 89.8 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6¹¹-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг мэдээлбэл зохих 128 байгууллагаас 90 нь буюу 70.3 хувь нь мэдээлсэн байна.

Өмнөх аудитаар хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг дунджаар 96.0 хувьтай мэдээлж байсан бол тус аудитаар 97.7 хувь болж 1.7 хувиар өсжээ.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д хамаарах 128 байгууллага 6.4–т заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасны дагуу шалгахад дараах байдалтай байв.

⁶ Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

⁷ Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор

⁸ Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор

⁹ Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухай жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор

¹¹ Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹², 6.4.2¹³-д заасан мэдээллийг 126 байгууллага буюу 98.4 хувь нь мэдээлсэн бол 6.4.3¹⁴-д заасан мэдээллийг 100 хувь мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4¹⁵-д заасан 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 12,630.5 сая төгрөгийн 758 гүйлгээнээс 1,607.6 сая төгрөгийн 148 гүйлгээг мэдээлээгүй байв.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5¹⁶-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг аймаг, сумдын Санхүү, төрийн сангийн хэлтэс, албадаас авсан лавлагаатай тулган шалгахад 1,134.7 сая төгрөгийн зарлагын 90 гүйлгээ, 53.1 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээг мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6¹⁷-д заасан мэдээллийг 99.2 хувь, 6.4.7¹⁸-д заасан мэдээллийг 98.4 хувь нь тус тус мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8¹⁹-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 6,247.1 сая төгрөгийн 1409 шийдвэрээс 234.8 сая төгрөгийн 37 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Өмнөх аудитын дүнтэй харьцуулбал зөрчлийн дүн 5,759.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагын холбогдох албан тушаалтнууд хуульд заасан мэдээллийг тогтмол байршуулж хэвшиж байгааг харуулж байна.



¹² Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

¹³ Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт

¹⁴ Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

¹⁵ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг

¹⁶ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр

¹⁷ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн

¹⁸ Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

¹⁹ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

1.4. Хуулийн 5 дугаар зүйлд шилэн дансны цахим хуудсанд тавигдах шаардлага, нийтлэг стандарт, агуулга, мэдээллийг иргэд, олон нийтэд хэрхэн хүргэх талаар хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7²⁰, 5.8²¹-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлын самбараар төсөв, санхүүгийн мэдээллээ иргэдэд хүргэж байна. Тухайлбал аймгийн ИТХ, ЗДТГ, Дархан сумын ИТХ, ЗДТГ, төрийн өмчийн 15-н ерөнхий боловсролын сургууль, 10 СӨБ-ын байгууллага, нийт 29 байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарын үйл ажиллагааг түүвэрлэн шалгахад сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, батлагдсан төсөв зэргийг мэдээлсэн байна.

²⁰ Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

²¹ Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

БҮЛЭГ 2

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах ААН-үүдийн 66 хувь нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаагүй байна.

2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3²²-т хамаарах төрийн өмчит хувьцаат компани 4, орон нутгийн өмчит хувьцаат компани 1, нийт 5 байгууллага байна. Тус байгууллагууд бүгд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэлтэй, мэдээллээ байршуулах боломжоор бүрэн хангагджээ.

2.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4²³-т хамаарах 50 аж ахуйн нэгж байгаагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй, мэдээлэл байршуулах боломжоор хангагдсан 17 аж ахуйн нэгж байна. Үлдсэн 33 аж ахуйн нэгж буюу 66 хувь нь бүртгэлгүй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-т “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ...”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

2.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах төрийн бус өмчийн 9 сургууль, 18 цэцэрлэг, 1 асрамжийн төв, нийт 28 байгууллага бүгд шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэлтэй, мэдээллээ байршуулах боломжоор хангагджээ.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах ААН-үүд 65 төсөл, хөтөлбөрийн 5.760,4 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

2.4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах байгууллагуудын хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1²⁴-д заасан мэдээллийг дээрх компаниуд бүрэн байршуулжээ.

²² Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

²³ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага

²⁴ Тухайн байгууллагатай холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр

Харин хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.2²⁵-д заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг “Дархан-Ус суваг” ХК, 6.8.3²⁶-д заасан худалдан авах ажиллагааны тайланг “Дархан АЗЗА” ТӨХК, “Дарханы Дулааны сүлжээ” ТӨХК, “Дархан-Ус суваг” ХК-ууд тус тус мэдээлээгүй байна.

Мөн “Дархан АЗЗА” ТӨХК, “Дулаан Шарын гол” ТӨХК-иуд хуулийн 6 дугаар зүйлийн 6.10²⁷-д “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэсэн заалтыг зөрчиж мэдээллээ байршуулаагүй байв. Үүнд холбогдох албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоо муу, уг хуулийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг шалтгаан нөлөөлжээ.

2.5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах, хамрагдвал зохих 50 аж ахуйн нэгжээс шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэлтэй, мэдээллээ байршуулах боломжоор хангагдсан нийт 17 аж ахуйн нэгж байна. Үүнээс 12 нэгж гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх мэдээллээ хууль, журамд заасан маягтын дагуу мэдээлсэн байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй ч мэдээллээ байршуулаагүй 4 аж ахуйн нэгж байна. Тухайлбал:

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төсөл, хөтөлбөрийн тоо	Олгосон санхүүжилт /сая.төг/
1	Өсөх-Урам ХХК	2	379.4
2	Цэн Ган ХХК	1	53.5
3	Болор Эрхэст Цамхаг ХХК	3	65.6
4	Их-Уулын хишиг ХХК	1	125.0
	Дүн	8	623.5
1	33 ААНэгж	57	5,136.9
	Дүн	57	5,136.9
	Нийт дүн	65	5,760.4

Мөн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлгүй 33-н аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна. Дээрх хүснэгтэнд уг 33-н аж ахуйн нэгжид олгосон санхүүжилт, төсөл, хөтөлбөрийн тоог нэгтгэн харуулав.

Иймд цаашид хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжд санхүүжүүлэгч /захиалагч/ байгууллагын зүгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэл үүсгэж, хуульд заасан мэдээллийг тогтмол мэдээлж байх үүрэгтэйг албан ёсоор мэдэгдэж, ажил гүйцэтгэх гэрээний заалтад тусгаж өгөх шаардлагатай байна.

2.6. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д хамаарах төрийн бус өмчийн 9-н ерөнхий боловсролын сургууль, 18-н цэцэрлэг, 1 асрамжийн төв бүгд шилэн дансны

²⁵ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

²⁶ Төрийн болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт

²⁷ “..., Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”

нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байгаагаас Монгол-Оюу, 24 дүгээр сургуулиуд санхүүжилтийн мэдээллээ огт байршуулаагүй байв.

Санхүүжилтийн мэдээллээ байршуулаагүй болон дутуу байршуулсан байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	4-р улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	Мэдээлээгүй санхүүжилтийн дүн /сая.төг/
			тийм-1, үгүй-2				
1	Монгол-Оюу	ЕБС	2	2	2	2	84.0
2	19 дүгээр сургууль	ЕБС	2	1	1	1	43.5
3	22 дугаар сургууль	ЕБС	1	2	2	2	25.8
4	24 дүгээр сургууль	ЕБС	2	2	2	2	96.4
5	Солонго	СӨБ	2	1	1	2	24.3
6	Төгс-Ундраа	СӨБ	1	1	2	1	23.6
7	Сүмдарьцэцэг	СӨБ	1	1	1	2	7.1
8	Цоглог жаалууд	СӨБ	1	1	1	2	3.2
9	Бурхантын жаргалант өргөө	СӨБ	1	1	1	2	2.8
Нийт дүн			4	3	4	7	310.7

Төсвөөс 2017 оны 4-р улиралд 226.3 сая, 2018 оны 1-3 дугаар улиралд 1.119,0 сая, нийт 1,345.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Үүнээс дээрх 9-н байгууллага нийт 310.7 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээллээ байршуулаагүй зөрчил илэрлээ.

Үүнийг өмнөх аудитаар илэрсэн зөрчлийн дүнтэй харьцуулж үзэхэд 217.8 сая төгрөгөөр өсжээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэж хүснэгтээр харуулбал:

Д/д	Хуулийн үйлчлэх хүрээ	Зөрчлийн дүн /сая.төг/	Шийдвэрлэсэн байдал	
			Зөвлөмж	Албан шаардлага
1	3.1.1, 3.1.2	3,030.2	-	3,030.2
2	3.1.4	5,760.4	-	5,760.4
3	3.1.5	310.7	310.7	-
Нийт дүн		9,101.3	310.7	8,790.6

Дээрх зөрчилд шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу 37 байгууллагын нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөгдсөн.

БҮЛЭГ 3

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-д заасан байгууллага, албан тушаалтан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсэн байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-д хамаарах байгууллага хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

3.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²⁸-д заасны дагуу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих шалгалтын удирдамж боловсруулж аймгийн ИТХ-ын даргаар батлуулсан байна.

Шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2018 оны 1 дүгээр улиралд 3 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 2 дугаар улиралд 4 сумын ИТХурал, 3 дугаар улиралд аймаг, сумдын ЗДТГазрын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөгөө мэдээлэл өгсөн байв.

Харин сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жилийн ажлын төлөвлөгөөндөө шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах хөтөлбөр, хувиар гарган ажиллажээ.

Тухайлбал Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дэргэдээ 7 гишүүний бүрэлдэхүүнтэй Төсөв санхүү, эдийн засгийн бодлого хяналтын хороог байгуулсан байна. Тус хяналтын хороо нь төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн ил тод байдал зэрэгт хяналт шалгалт хийж, нягтлан бодогч нарт зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Мөн Хонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 10-н байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэдээллийг удаа дараа хоцроосон сумын ЗДТГазрын нягтлан бодогчид хариуцлага тооцох албан бичиг хүргүүлсэн байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуульд заасны дагуу ТЕЗ хэрэгжүүлэхээр зааж өгсөн.

Дотоод хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна. Тус алба нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2 удаагийн шалгалтаар давхардсан тоогоор нийт 169-н байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж зөрчил гаргасан 15-н төсвийн шууд захирагчид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичиг хүргүүлжээ. Мөн тус албанаас төсвийн захирагч болон нягтлан бодогч нарт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулснаар зөрчил тодорхой хувиар буурсан байна.

3.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.5-д хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт,

²⁸ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ

аудитын албанаас 2017, 2018 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгасан байна.

Шалгалтаар хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК, “Дулаан шарын гол” ТӨХК, “Дархан АЗЗА” ТӨХК-нуудын хуулийн хэрэгжилт 98 хувьтай, “Дархан-Ус суваг” ХК-ны хэрэгжилт 84 хувьтай хэрэгжиж байна гэж дүгнэжээ.

Харин хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгжийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д хамаарах 28 байгууллагын хэрэгжилт дунджаар 94 хувьтай байсан байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж 66 хувьтай хэрэгжсэн байна.

3.3. Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй 23 байгууллагын нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгч, бүрэн хэрэгжсэн.

3.4. Өмнөх аудитаар дараах байгууллага, албан тушаалтанд 3 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд:

1. Аймгийн Засаг дарга С.Насанбатад:

Зөвлөмж-1: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч төрийн бус өмчийн байгууллагуудад санхүүжилт олгохдоо шилэн дансны мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг харгалзан үзэх.

Хэрэгжилт: Хэрэгжээгүй байна.

Зөвлөмж-2: Шилэн дансны тухай хуулийг сурталчлан, биелэлтийг нь хангах ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилт: Зөвлөмжийн дагуу төсвийн захирагчид болон нягтлан бодогч нарт Санхүү хяналт, аудитын албанаас сургалт зохион байгуулсан байна.

2. Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын ИТХ-ын дарга нарт:

Зөвлөмж-3: Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хэрэгжилт: Сумдын ИТХ жилийн ажлын төлөвлөгөөндөө шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаар тусгаж өгсөн байна. Үүний дагуу хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчилд тухай бүрт нь зөвлөгөө өгч ажилласан байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 66 хувьтай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**ХОЁР: ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллээ тогтмол байршуулж хэвшиж байна.
2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ГУРАВ: ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Насанбатад

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, ажил гүйцэтгэх гэрээний заалтад шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар тусгаж өгөх.

Аймгийн БСУГ-ын дарга Б.Гантулгад

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч хувийн хэвшлийн байгууллагуудад санхүүжилт олгохдоо шилэн дансны мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг харгалзан үзэх.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР